



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 650

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 31,657,500.00 /гучин нэгэн сая зургаан зуун тавин долоон мянга таван зуун / төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн цаашид ашиглаж болох тракторын ашиглах хугацааг сунгаж, үнийг 18,000,000.00 / арван найман сая/ төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Улсын нөөцийн Объект-03 салбарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын дарга хурандаа С.Пүрэвсамдан, Улсын нөөцийн Объект-03 салбарын дарга, хошууч Б.Ганбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг хүлээлцэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн  
650 дугаар тогтоолын хавсралт

Дархан-Уул аймгийн онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй  
үлдэх өртөггүй, ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоон Улсын  
нөөцийн объект -03 салбарт балансаас балансад шилжүүлэх хөрөнгө

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Кубота трактор M9000	2001/2001	31,657,500.00	18,000,000.00	7
2	Нийт дүн		/гучин нэгэн сая зургаан зуун тавин долоон мянга таван зуун/	/арван найман сая/	